

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МЭДЭЭЛЛИЙН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН
ОРЧНЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Ш.Батболд*, Б.Наранбаатар**

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

** МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, дэд профессор, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: үндэсний мэдээллийн агентлаг, эрх зүйн орчин, цаашдын шаардлага

Монголын үндэсний мэдээллийн агентлаг /МОНЦАМЭ/-ийн түүхийг нягтлан үзэхэд анх тус газрыг байгуулах асуудлыг МАН /МАХН/-ын Төв хорооны гишүүдийн өргөтгөсөн хурлаар 1921 оны 5 дугаар сарын 19-ний өдөр хэлэлцэж, МОНТА хэмээх нэр бүхий цахилгаан мэдээг сурвалжлан хурааж нэвтрүүлэх газрыг байгуулахаар Засгийн газарт шилжүүлсэн тогтоол гарч байжээ (Монгол ардын хувьсгалт намын тогтоол шийдвэр баримт бичгүүд, 1981). Улмаар Ардын хувьсгалын ялалтыг тунхагласны дараахан буюу 1921 оны 7 дугаар сарын 19-ний Ардын засгийн газрын 6-р хуралдааны тогтоолын 2 дахь заалтаар Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан байна (Ардын засгийн газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд, 1954). Өөрөөр хэлбэл, Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хорооны бүтцэд одоогийн шуудан, холбооны байгууллагатай хамт Монголын цахил-

гаан мэдээний агентлаг МОНТА-г байгуулжээ гэж үзэж байгаа юм.

МОНТА буюу Монголын цахилгаан мэдээний газрыг байгуулахдаа Дотоод хэргийн яамны харьяанд хамааруулж байснаа удалгүй Гадаад явдлын яам, Цэргийн яамны харьяанд шилжүүлж, улмаар 1923 оны 7 дугаар сард хуралдсан МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн шийдвэрээр “Уриа” сониныг МОНТА буюу МОНЦАМЭ агентлагийн хэвлэл “Хураангуй сэтгүүл”-тэй нийлүүлж нэгтгээд “Нийслэлийн шинэ сонин” нэрээр гаргах болсон байна. Дараа жил нь буюу 1924 оны 2 дугаар сард МАХН-ын Төв хороо, Засгийн газрын хамтарсан шийдвэрээр “Нийслэлийн шинэ сонин”-г “Ардын эрх” сонин болгон дахин өөрчлөн зохион байгуулжээ. Улмаар 1925 оны 4 дүгээр сард МАХН-ын Төв хороо, Бүх Монголын ХЗЭ-ийн шийдвэрээр дахиад л “Ардын эрх” сониныг хэвлэхээ зогсоож, “Үнэн” нэрээр гаргаж эхэлсэн байна (Монголын үндэсний мэдээллийн агентлаг үүсэж хөгжсөн нь, 2021). МОНТА эдгээр сонинд гадаад мэдээллийг нийлүүлэх үндсэн үүргээ гүйцэтгэсээр байжээ. Гэхдээ Шуудан бичиг, цахилгаан

мэдээний ерөнхий хорооны бүтцэд цахилгаан мэдээ хүлээн авч орчуулж мэдээлэх, гадаадад мэдээ мэдээлэл дамжуулдаг ажлыг хариуцан 1930-аад оны дунд үе хүртэл ажилласан нь сүүлийн үеийн баримтуудаар тодорхой болоод байгаа юм (Монгол-Зөвлөлтийн харилцаа 1921-1974. Баримт бичиг, материалын эмхэтгэл. I боть, 1976).

1 930-аад оны сүүлч, 1940-өөд онд МАХН-ын Төв хороо, 1942 оноос “Үнэн” сонины дэргэд орос хэлээр “Унен-Правда” сониныг гаргаж “Үнэн” сонины бүхий л мэдээллийг орос хэл рүү орчуулах, 1943 оноос “Үнэн” сонинд Зөвлөлтийн мэдээлэх товчооны мэдээллийг орчуулж байсан МОНТА-г 1957 онд МОНЦАМЭ нэрээр шинээр сэргээн байгуулахдаа эхлээд “Үнэн” сонины дэргэд байгуулсан МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоол гарч байв (Монголын цахилгаан мэдээний агентлаг байгуулах тухай, 1957). Гэвч удалгүй БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1957 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хавсарсан 430/363 дугаар тоот тогтоолоор Монголын Цахилгаан Мэдээний агентлаг /МОНЦАМЭ/-ийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэд тусгай газар хэлбэрээр ажиллуулахаар шийдвэрлэсэн байна (Монголын цахилгаан мэдээний агентлагийг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэд ажиллуулах тухай, 1957). Ийнхүү МОНЦАМЭ агентлаг ахин бие даан байгуулагдаж дэлхийн бусад улс орны нийтлэг жишгээр ажиллах болсноор үндэсний мэдээллийн агентлагийн үнэн бодит дүр төрхөө жинхэнэ утгаар нь олж авчээ (Т.Баасансүрэн, 2016).

БНМАУ-д 1959 оноос Мэдээлэл, радиогийн хороо, 1967 онд Монгол телевиз байгуулагдсанаар Мэдээлэл, радио, телевизийн улсын хороо хэмээх байгууллага ажиллаж байсны МЭДЭЭЛЭЛ хэмээх тодотгол нь МОНЦАМЭ агентлаг бөгөөд ийм бүтцээр 1990 он хүртэл үйл ажиллагаа явуулжээ. Харин 1990 онд МОНЦАМЭ агентлагийг БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх мэдээллийн агентлаг болгон өөрчлөн зохион байгуулж, Монгол орны дотоодод болон хилийн чанадад болж байгаа үйл явдлыг шуурхай мэдээлэх, Засгийн газрын нэрийн өмнөөс түүний байр суурийг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбар гаргах бүрэн эрх, үүргийг хүлээлгэсэн байна (Засгийн газрын дэргэд "МОНЦАМЭ" агентлаг байгуулж ажиллуулах тухай, 1990). Улмаар 2000 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 139 дугаартай тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн нэг болгож, Ерөнхий сайдын шууд мэдэлд ажиллуулах болсон байна (Агентлаг байгуулах тухай, 2000). Ийнхүү үйл ажиллагаа явуулж ирсэн МОНЦАМЭ агентлагийг 2005 онд Засгийн газраас Монгол Улсын Гадаад Хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд байлгахаар санал болгосон боловч сэтгүүлчид, нийгмийн өргөн олны зүгээс хурц эсэргүүцэл, шүүмжлэлд өртөж уг асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй, МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчин, харьяалал тодорхойгүй үлджээ. Ингэснээр тус агентлаг албан ёсны Засгийн газрын агентлагуудын тоонд багтахгүйгээр Ерөнхий сайдын төсвийн багцын хүрээнд үйл ажиллагаа явуулж, удирдлагыг нь Ерөнхий сайд шууд томилж ирсэн байна.

Харин хамгийн сүүлд Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 400 тоот тогтоолоор МОНЦАМЭ агентлагийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын харьяанд шилжүүлж шийдвэрлэжээ (Мэдээллийн "МОНЦАМЭ" агентлагийн талаар авах арга хэмжээний тухай, 2021).

Гэвч энэ нь МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчныг тодорхой болгох шийдэл биш, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн зөрчил арилаагүй хэвээр байна. Учир нь 1998 онд батлагдсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4-р зүйлд "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно" хэмээн заасан (Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, 1998). Энэхүү хууль батлагдсаны дараа УИХ-аас 1998 онд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 тоот тогтоол гаргаж, түүний 4-р зүйлд "Радио, телевизийн хэрэг эрхлэх газар, МОНЦАМЭ агентлагийг Засгийн газрын агентлагийн хувьд татан буулгаж, Үндэсний нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болгон өөрчлөн зохион байгуулсугай" (Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай, 1998) гэж заасан юм. Радио, телевизийн хэрэг эрхлэх газрыг уг тогтоолын дагуу 2005 онд Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн тухай хууль гарган зохион байгуулж, харин МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчин тодорхойгүй, зөрчилтэй үлджээ.

Өнгөрсөн хугацаанд МОНЦАМЭ агентлагийн төрийн агентлагийн хууль эрх зүйн орчин тодорхойгүй болсонтой

холбогдуулж, эл асуудлыг хууль гаргах замаар шийдвэрлэхээр тус агентлагаас ХЗДХЯ-тай хамтран ажлын хэсэг гаргаж, удаа дараа хуулийн төсөл боловсруулан 2007, 2011 онд Засгийн газарт өргөн барьсан ч өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй байна. ХЗДХЯ-наас "Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа", "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан", "Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал" зэргийг хийжээ.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын түвшинд боловсруулагдаж байсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдэд удаа дараа саналаа тусгуулж байжээ. Тухайлбал, 2013 онд Монгол Улсын Ерөнхийлөгч санаачлагч болон УИХ-д өргөн барьсан /хэлэлцүүлгийн явцад төслөө эргүүлэн татаж аваад дахиж өргөн бариагүй/ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 6.1.3-д "Засгийн газар Монгол Улсын тухай мэдээллийг дэлхий дахинд түгээх, сурталчлах үйл ажиллагаа эрхэлдэг мэдээллийн хэрэгсэлтэй байж болно. Үүнтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулна" гэж тусгуулсан байна.

Түүнчлэн ХЗДХ-ийн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн 2019-2020 боловсруулсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 4.4-д "Засгийн газар дэргэдээ Монгол Улсын тухай мэдээллийг дэлхий дахинд түгээх, сурталчлах үндсэн үйл ажиллагаа

эрхэлдэг мэдээллийн хэрэгсэлтэй байж болно. Үүнтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулна” хэмээсэн заалт оруулж байжээ. Харамсалтай нь эдгээр хуулийн төслүүд УИХ, Засгийн газрын түвшинд өргөн баригдаж хэлэлцэгдээгүй өнөөдрийг хүрсэн тул МОНЦАМЭ агентлагийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт шилжүүлэх байдлаар Засгийн газар асуудлыг түр шийдсэн болжээ.

Цаашид одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4-р зүйл дэх “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” хэмээсэн заалтын араас

1-р хувилбар, “Дээрх заалт нь Монгол Улсыг гадаадад сурталчлах үүрэг бүхий үндэсний мэдээллийн агентлагт үл хамаарна”,

2-р хувилбар, “Дээрх заалт нь Монгол Улсыг гадаадад сурталчлах үүрэг бүхий үндэсний мэдээллийн агентлагт үл хамаарна. Үндэсний мэдээллийн агентлаг нь Монгол Улсын Ерөнхийлөгч/ Засгийн газрын дэргэд ажиллах бөгөөд үйл ажиллагааны дүрмийг Ерөнхийлөгчийн Тамгын газар/ Зас-

гийн газар батална” /ОХУ-ын ТАСС агентлагийн жишиг/,

3-р хувилбар, “Монгол Улс нь өөрийн орны тухай мэдээллийг дэлхий дахинд түгээх, сурталчлах үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг мэдээллийн хэрэгсэлтэй байж болно. Үүнтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулна” гэсэн агуулгатай нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн төслийг холбогдох эрх бүхий субъектээр санаачлуулан батлуулах нь МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчныг тодорхой болгох хамгийн оновчтой арга зам юм.

Хуульд ийм өөрчлөлт орсны дараа МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчныг тодорхой болгож шийдвэрлэхэд хууль зүйн зөрчилгүй болох бөгөөд үргэлжлүүлэн “Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай” /“МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн байдлын тухай”/ хуулийн төслийг боловсруулж УИХ-аар бат-

луулах, эсвэл Ерөнхийлөгчийн Тамгын газар/ Засгийн газраар “Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн үйл ажиллагааны дүрэм”-ийг шинээр батлан хууль/ дүрэмд мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, зарчмыг улс

«

Цаашид одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4-р зүйл дэх “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” хэмээсэн заалтын араас “Дээрх заалт нь Монгол Улсыг гадаадад сурталчлах үүрэг бүхий үндэсний мэдээллийн агентлагт үл хамаарна” эсвэл “Монгол Улс нь өөрийн орны тухай мэдээллийг дэлхий дахинд түгээх, сурталчлах үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг мэдээллийн хэрэгсэлтэй байж болно” гэсэн агуулгатай нэмэлт өөрчлөлт оруулсан хуулийн төслийг холбогдох эрх бүхий субъектээр санаачлуулан батлуулах нь МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчныг тодорхой болгох хамгийн оновчтой арга зам юм

»

орон, нийгмийн хөгжлийн өнөөгийн хандлагатай нийцүүлж уялдуулан тодор-хой тусгаж өгөх хэрэгтэй байна.

Дэлхий дахинд үндэсний мэдээллийн агентлаг бол аливаа улсын тусгаар тогтнолын баталгаабэлгэ тэмдэг байдаг бөгөөд тухайн улсын төр засгийн бодлогыг дотоод, гадаадад хүргэдэг дуу хоолой нь болдог. Тиймээс дэлхийн том, жижиг бараг бүх л улс орон үндэсний мэдээллийн агентлагтай, тэдний ихэнх нь шууд төрийн мэдэлд байж улс орноо дотооддоо төдийгүй гадаадад сурталчлах үүрэг хүлээдэг. Тухайлбал, ОХУ-“Россия Сегодня”, ТАСС, БНХАУ-XINHUA, АНУ-BBG /VOA/, Франц-AFP, ХБНГУ-Deutsche Welle /DW/, Их Британи-BBC, Австрали-ABC, Азербайжан-Azertac, Турк-Anadolu, Казахстан-КАЗИН-ФОРМ, Энэтхэг-PTI, Индонез-Antara, Вьетнам-VNA, Малайз-Bernamea, Иран-IRNA, БНАСАУ-KCNA, Украин-УКРАИНФОРМ, Куба-Prensa Latina, Польш улс-PAP зэрэг үндэсний болон олон нийт, олон улсын мэдээллийн агентлагтай. Эдгээр агентлаг нь төр засагтаа шууд болон шууд бусаар хамаарч ажилладаг, тухайн улс орныхоо байр суурь, төр засгийнхаа үйл ажиллагаа, бодлогыг дэлхий дахинд мэдээлэн сурталчилдаг. БНСУ-ын Yonhap, Япон улсын Kyodo зэрэг хувь нийлүүлсэн нийгэмлэг, хоршоолол хэлбэрээр ажилладаг ч төр засгийнхаа тухай мэдээлэл, бодлого шийдвэр, байр суурийг дотоод, гадаадад түгээх үүрэг давхар хүлээдэг, үүнийхээ төлөө Засгийн газраасаа тодорхой хэмжээний байнгын санхүүжилт авдаг мэдээллийн агентлагууд ч байна.

Монгол Улс зэрэг хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын хувьд

мэдээллийн агентлагууд нь ихэнхдээ 100 хувь төрийн мэдэлд ажиллаж, төрийн бодлого, чиглэлийн дагуу нэг сувгаар улс орноо гадаадад сурталчлах гол эх сурвалж болдог жишигтэй. Энэ жишгээр бол тусгаар тогтносон Монгол Улс гэж байгаа тохиолдолд үндэсний мэдээллийн агентлаг байх нь зүй ёсны хэрэгцээ шаардлага бөгөөд эрх зүйн хувьд ч ямар нэгэн маргаангүй зохицуулалттай байхаас аргагүй юм.

Дэлхий ертөнц улам бүр даяаршиж, мэдээллийн технологи/нийгмийн мэдээллийн сүлжээ хөгжихийн хэрээр бодитой, баталгаатай мэдээллийн хэрэгцээ шаардлага байнга өсөн нэмэгдэж байгаа энэ цаг үед үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчныг тодорхой болгох нь:

- Гадаадад сурталчлах үйл ажиллагаанд МОНЦАМЭ агентлагийн үүрэг оролцоог улам нэмэгдүүлж, төрийн нэгдсэн бодлоготой уялдуулан ажиллуулах,
- Монгол Улс дэлхий дахинд өөрийгөө улам бүр системтэйгээр сурталчлан таниулж, бодлого, зорилгоо олон улсын хэмжээнд хүргэх,
- Олон улсын тавцанд Монгол Улсын байр суурь, нэр хүндийг өсгөх,
- Үндэстний дархлаагаа нэмэгдүүлэх,
- Гадаадын хөрөнгө оруулалт татах,
- Аялал жуулчлал хөгжүүлэх орчныг бодитойгоор бий болгох зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Монгол Улсыг төлөөлөх үндэсний мэдээллийн агентлагийн үүргийг өнгөрсөн хугацаанд МОНЦАМЭ агентлаг гүйцэтгэж, олон нийтийг дотоод, гадаад үйл явдлын мэдээгээр хангах, Монгол Улсын байр суурь, бодлого

шийдвэр, үндэсний онцлогтой өв соёл, ёс заншил, хөгжил дэвшлийн ололт амжилтыг сурталчилж тайлбарласан мэдээллийг гадаад орнуудад түгээн дэлгэрүүлэх ажлыг хийж ирсэн. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай холбоотойгоор сүүлийн жилүүдэд эрх зүйн орчин тодорхойгүй байсан ч МОНЦАМЭ агентлаг уламжлалт, тогтсон жишгийн дагуу үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна.

Монгол Улсын гадаад болон дотоод мэдээлэл сурталчилгааг дагнан явуулж ирсэн уламжлалт бааз суурь, боловсон хүчний нөөцтэй, улсын төсвөөс авдаг үйл ажиллагааны төсөвтэй учир МОНЦАМЭ агентлагийн эрх зүйн орчныг тодорхой болгосноор нэмэлт зардал төрөөс шаардагдахгүй. Мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын холбогдох заалтад ч нийцэх юм. Тухайлбал, УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.4.4-т “Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана” гэж заасан. Түүнчлэн УИХ-ын 2011 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 28-д “...Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх” гэж, 29-д “Монгол Улсын түүх, соёлын уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилтыг гадаадад

сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх, гадаад сурталчилгааны бүтэц бий болгохыг дэмжих” хэмээн зааж өгч үндэсний гадаад сурталчилгааны ач холбогдлыг тодотгосон байна.

Эшлэл

1. МАХН-ын тогтоол шийдвэр баримт бичгүүд. 1981. УБ. Ху 453.
2. Ардын засгийн газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд, 1954. УБ. Ху 206.
3. Монголд үндэсний мэдээллийн агентлаг үүсэж хөгжсөн нь: Дэлхийн мэдээллийн агентлагуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. (МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). 2021. УБ. Ху 130.
4. Монгол-Зөвлөлтийн харилцаа 1921-1974. Баримт бичиг, материалын эмхэтгэл. I боть. 1921-1940. 1976. УБ. Ху 368.
5. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоол. 1957. №260. УБ. Ху 3.
6. БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны хавсарсан тогтоол. 1957. №430/363. УБ. Ху 1.
7. Баасансүрэн Т. МОНТА буюу МОНЦАМЭ-ийн өчигдөр, өнөөдөр, маргааш. (Мэдээллийн агентлагийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлага. МОНЦАМЭ агентлагийн 95 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). 2016. УБ. Ху 68.
8. БНМАУ-ын Засгийн газрын тогтоол. 1990. №14. УБ. Ху 1.
9. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2000. №139. УБ. Ху 2.
10. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2021. №400. УБ. Ху 1.
11. Монгол Улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. 1998. УБ. Ху 1.
12. Монгол Улсын Их Хурлын тогтоол. 1998. №103. УБ. Ху 1.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. МАХН-ын тогтоол шийдвэр баримт бичгүүд. 1981. УБ.
2. Ардын засгийн газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. 1954. УБ.
3. Монголд үндэсний мэдээллийн агентлаг үүсэж хөгжсөн нь: Дэлхийн мэдээллийн агентлагуудын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. (МОНЦАМЭ агентлагийн 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). 2021. УБ.
4. Монгол-Зөвлөлтийн харилцаа 1921-1974. Баримт бичиг, материалын эмхэтгэл. I боть. 1921-1940. 1976. УБ.
5. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны тогтоол. 1957. №260. УБ.
6. БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны хавсарсан тогтоол. 1957. №430/363. УБ.
7. Мэдээллийн агентлагийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хөгжлийн чиг хандлага. (МОНЦАМЭ агентлагийн 95 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл). 2016. УБ.
8. БНМАУ-ын Засгийн газрын тогтоол. 1990. №14. УБ.
9. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2000. №139. УБ.
10. Монгол Улсын Засгийн газрын тогтоол. 2021. №400. УБ.
11. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
12. Түдэв Л. 2005. Он цагийн мэдээ (Бүтээлийн чуулган ХХIX боть). УБ.
13. Миний нэр, Миний гэр-МОНЦАМЭ. 2001. УБ.
14. Баасансүрэн Т. 2009. “ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл” (Тэргүүн дэвтэр, II хэсэг). УБ.
15. Батболд Ш. 2022. №23/581. МОНЦАМЭ агентлагийн эхэн үеийн түүхэнд холбогдох зарим баримтыг тодруулах нь. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг “Сэтгүүл зүй сэтгүүл”. УБ.
16. Батболд Ш. 2023. №01. Шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороонд МОНТА/МОНЦАМЭ хамаарч байсныг тодотгох зарим баримт. МУБИС-ийн “Монгол судлалын чуулган” эрдэм шинжилгээний сэтгүүл. УБ.
17. Монгол Улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. 1998. УБ.
18. Монгол Улсын Их Хурлын тогтоол. 1998. №103. УБ.
19. Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд хийсэн судалгаа. 2011. УБ.
20. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан. 2011. УБ.
21. Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2011, 2017. УБ.

Summary

The National News Agency of Mongolia MONTSAME is an organization that for many years has been working to provide the domestic public with news about events taking place in the country and abroad, familiarize foreign consumers with the position, policies, decisions of Mongolia, disseminate information related to national cultural heritage, traditions and customs.

However, in connection with the Law “On Freedom of the Press”, adopted by the State Great Khural in 1998, an uncertain legal environment for this organization arose and exists to this day. This article addresses the issue that in current period of deepening globalization and the growing need for real and reliable information in the world, it is very important to create a specific legal environment for the MONTSAME news agency by introducing changes and additions to the Law of Mongolia “On Freedom of the Press”.

Keywords: national news agency, legal framework and future requirements, MONTSAME.